Барилгын политехник коллеж нь мэргэжлийн ур чадвар, зөв хандлага, төлөвшилтэй мэргэжилтэн бэлтгэж, салбартаа тэргүүлэх эрхэм зорилго дэвшүүлэн мэргэжлийн боловсрол олгох сургалтыг 10 мэргэжлээр, техникийн боловсрол олгох сургалтыг 7 мэргэжлээр нийт 75 бүлгийн 2095 суралцагчдад цахимаар болон танхимаар сургалтын үйл ажиллагааг тус тус явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 43 дугаар тогтоол;
- Засгийн газрын тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Барилгын политехник коллеж нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 3,531,081.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 35,310.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Барилгын политехник коллежийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,791,861.1 мянган төгрөгөөр буюу 67.5 хувиар өсөж, материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	19.6	19.6	-
Авлага	62,540.4	28,111.4	(34,428.9)
Урьдчилгаа	6,655.1	2,195.3	(4,459.8)
Бараа материал	462,439.5	376,729.1	(85,710.4)
Үндсэн хөрөнгө	3,602,352.6	6,518,812.8	2,916,460.2
Нийт хөрөнгө	4,134,007.1	6,925,868.2	2,791,861.1
Өр төлбөр	64,211.4	30,581.7	(33,629.7)
Засгийн газрын оруулсан капитал	4,022,413.2	4,022,413.2	-
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,113,733.0	1,106,160.1	7,572.9
Хуримтлагдсан үр дүн	(1,066,350.5)	1,766,713.2	2,833,063.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,134,007.1	6,925,868.2	2,791,861.1

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл нь 34,428.9 мянган төгрөгөөр буурсан нь мэргэшүүлэх сургалтын болон бусад авлагын дүн 70,013.9 мянган төгрөгийн авлага шинээр үүсэж, 104,442.8 мянган төгрөгийн авлагыг цуглуулж ажилласан;
- Тайлант онд төсвийн хөрөнгөөр 142,412.2 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, хандиваар 47,234.1 мянган төгрөгийн бараа материал хүлээн авсан

ба 275,356.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, бараа материал дансны үлдэгдэл 376,729.1 мянган төгрөг болж өмнөх үеэс 85,710.4 мянган төгрөгөөр буурсан;

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,916,460.2 мянган төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн 2,249,784.8 мянган төгрөгийн дадлагын байр, 205,537.0 мянган төгрөгөөр дадлагын тоног төхөөрөмж, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн хандиваар 115,483.7 мянган төгрөгийн төхөөрөмж хүлээн авсан, ТӨБЗГ-ын 2021 оны 87 дугаар тогтоолын дагуу 2,060,025.2 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлээр анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосны дагуу 932,546.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр бүртгэсэн зэргээс тус тус шалтгаалсан.
- Өр төлбөр 33,629.7 мянган төгрөгөөр буурсан нь дотуур байрны хоолны тооцооны өглөг 19,693.7 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 5,205.8 мянган төгрөгийн төлөлтийг тайланд хугацаанд тус тус төлснөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Барилгын политехник коллеж нь 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 4,029,675.3 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 4,029,675.3 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвөөс урсгал зардлыг 733,428.7 мянган төгрөгөөр бууруулан 3,296,246.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Үүнээс зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,095,958.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 148,460.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагаанаас, 51,828.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Төсвийн тодотголоор санхүүжилтийн эх үүсвэрийг 91,334.9 мянган төгрөгөөр бууруулж 3,204,911.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,004,623.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 148,460.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагаанаас, 51,828.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,999,130.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 144,437.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 35,327.3 мянган төгрөг, нийт 3,178,836.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,178,836.0 мянган төгрөгийг зарцуулж, 5,492.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, 99.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,178,836.0 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь нийгмийн даатгалын шимтгэл 12,449.9 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 10,149.2 мянган төгрөгөөр, нормативт зардал 2,201.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Хүснэгт – 3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл.

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71804	Тусгай мэргэжлийн боловсрол	3,204,911.7	3,178,836.0	26,075.6	99.2
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,904,119.5	2,881,353.9	22,765.5	99.2
1.2	80219	Харуул хамгаалалтын зардал	57,200.0	56,090.9	1,109.0	98.1
1.3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	37,271.4	37,271.4	-	100.0
1.4	80813	Хуульд заасан үндэслэлээр албан хаагчид олгох нөхөн олговор	128,068.1	128,068.1	-	100.0
1.5	81806	Дотуур байрны хүүхдийн хоол	78,252.7	76,051.7	2,201.0	97.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд багш нарын цалин бусад зардалд 37,468.8 мянган төгрөг, мөн өмнөх оны үлдэгдэл 117.6 мянган төгрөг нийт 37,586.4 мянган төгрөг төвлөрүүлжээ.

Үүнээс багш нарын цалин, нийгмийн даатгалд 34,880.0 мянган төгрөг, хоолны зардал 2,400.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 306.4 мянган төгрөг, нийтдээ 2,706.4 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.2 хувийн биелэлттэй, 0.8 хувь буюу 26,075.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Тайлант онд сургалтад шинэ технологи нэвтрүүлэх, сургалтын орчныг шинэчлэн сайжруулах ажлын хүрээнд Мянганы сорилтын сан, Азийн хөгжлийн банк, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг нэвтрүүлэх, анги, танхим, дадлагын байрыг засварлах, шинэчлэн барих ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкнаас дадлагын газрын барилгын хөрөнгө оруулалтад 2,249,784.8 мянган төгрөг, тоног төхөөрөмжийн шинэчлэлд 366,025.3 мянган төгрөг, бараа материал болон бусад зүйлд 47,234.0 мянган төгрөг, нийт 2,700,539.2 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг авсан байна.

3.8 Аудитын гол асуудал

ТӨБЗГ-ын 2021 оны 87 тоот тогтоолоор 578 нэрийн нийт 2,060,025.2 мянган төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 1,119,888.6 мянган төгрөгөөр тогтоосныг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар 569 нэрийн 932,546.3 мянган төгрөг болгон үндсэн хөрөнгийг 187,342.3 мянган төгрөгөөр бууруулж бүртгэсэн. Энэ нь өмч хамгаалах байнгын зөвлөл хугацаа сунгаж, үнэлгээ тогтоох хөрөнгийн мэдээллийг зөрүүтэй бэлтгэж хүргүүлснээс шалтгаалжээ. Иймд ТӨБЗГ-т ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт, мэдээллийг хүргүүлэхдээ ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолд заасан шаардлагын дагуу бүрдүүлж байх, өмч хамгаалал байнгын зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд оруулбал зохих 149 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроон, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, Хариуцлага тооцох шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 149,717.5 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илрүүлснээс 3,969.1 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, 145,748.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад өмч хамгаалах байнгын зөвлөл үндсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой асуудлыг хэлэлцэж, жагсаалтыг гаргасан, анхан шатны баримтын зөрчилтэй 3 ажил гүйлгээг холбогдох ажилтнаар бүрдүүлэлтийг хийлгэсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгснийг бүрэн ханган биелүүлж, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, Үндэсний аудитын газарт 2021 оны 3/55 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	2,071.4	1	2,071.4	1	-	98.0
Зөвлөмж	1	8,460.0	1	8,460.0	-	-	100.0
Нийт дүн	3	10,531.4	3	10,531.4	1	-	99.0

/мянган төгрөг/

Өмнөх аудитаар дотуур байрны хүүхдийн хоолны зардал, түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт төвлөрүүлээгүй зэрэг асуудлаар өгсөн зөвлөмж албан шаардлагыг 100.0 хэрэгжүүлсэн, шилэн дансны мэдээлэл хоцроосон албан шаардлагыг 98.0 биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын төлөвлөлт, зарцуулалтыг шалгах шаардлагатай гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 176,364.9 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 169,216.2 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 2,923.4 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3,229.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 6,152.7 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 29,158.1 мянган төгрөгөөр бага байгаа тул “зөрчилгүй” дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 168,755.0 мянган төгрөгийн хөрөнгийн ангилал буруу тайлагнасан;
- Өмнөх оны цэвэр хөрөнгийн тайлан нь өмнөх оны аудитлагдсан цэвэр хөрөнгийн тайлангаас дахин үнэлгээний нэмэгдлийн 411.2 мянган төгрөгийн зөрүүтэй байсан.

4.2 Албан шаардлага

Тайлант хугацаанд захиргаа, үйлчилгээний ажилтнуудад илүү цагийг журамд заасан хэмжээнээс өндрөөр тооцоолж, 2,923.4 мянган төгрөгөөр илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгосон.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.3-т “ Илүү цагаар,

долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна”, 4.1-д “1. Нарийн төвөгтэй ажилбар болон анхаарал төвлөрөл шаардах ажил гүйцэтгэдэг эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний зарим албан хаагчийг шөнийн цагаар ажиллуулсан тохиолдолд мэргэжлийн алдаа гаргах, үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд үүсэх эрсдэлээс сэргийлж, түүнийг нөхөн амруулна. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд шөнийн цагаар ажилласан төрийн албан хаагчтай зөвшилцсөний үндсэн дээр түүнийг үргэлжлүүлэн ажиллуулж, энэ журмын дагуу нэмэгдэл хөлсийг тодорхойлно” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захиргаа, үйлчилгээний ажилтнуудын илүү цагийг журамд заасан хэмжээгээр тооцож байх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материал, үндсэн хөрөнгийн түүвэр тооллогын горим гүйцэтгэхэд 308.0 мянган төгрөгийн алмаазан жижиг ир 8 ширхэг дутуу, 162.0 мянган төгрөгийн хэв хашмалын хавчаар 1 ширхэг илүү, 48.4 мянган төгрөгийн дижитал тэгш ус 1 ширхэг илүү зэрэг зөрүүтэй тоологдсон бөгөөд тооллого хийхээс өмнөх өдрүүдийн бараа материалын орлого, зардлын гүйлгээг бүртгэлд тусгаагүйгээс шалтгаалжээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "бүх орлого, бүх зардал"-ыг нягтлан бодох бүртгэлд тусгана гэж заасантай нийцээгүй, үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын орлогыг орсон, зарлагыг гарсан тухай бүрт нь бүртгэж, баримтжуулж ажиллах;

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Коллежийн дадлагын газрын байранд ашиглагдаж буй суурь машин тоног төхөөрөмж техник ашиглалтын картгүй, дадлагын газрын хөрөнгийн хөдөлгөөнд тавих хяналт сул байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 2 дахь заалт "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасан нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сургалтын үйл ажиллагаанд ашиглагдаж буй машин тоног төхөөрөмжийг техник ашиглалтын карттай болгох, үндсэн хөрөнгийн байршил, эзэмшигч солигдох тухай бүрд тэмдэглэл хийх, өмч хамгаалах байнгын зөвлөлөөс тавих хяналтыг сайжруулах;

3. Авлага, өглөгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсөвт байгууллага нь тайлант хугацааны эцсээр ажилтнууд болон байгууллагуудтай 3,229.3 мянган төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдэл, тооцоотой гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг баримтална гэж заасныг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант хугацааны эцэст өр, авлагын тооцоог оновчтой удирдаж, төлбөр тооцооны үлдэгдэлгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Барилгын политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	БПК	АХГ-2022/243/НА-СТА-ТШЗ	Коллежийн дадлагын газрын байранд ашиглагдаж буй суурь машин тоног төхөөрөмж техник ашиглалтын картгүй, дадлагын газрын хөрөнгийн хөдөлгөөнд тавих хяналт сул байна.	Машин тоног төхөөрөмжийг картжуулах, хяналтыг сайжруулах										1	-	
6	БПК	АХГ-2022/243/НА-СТА-ТШЗ	Төсөвт байгууллага нь тайлант хугацааны эцсээр ажилтнууд болон байгууллагуудтай авлага, өглөгийн үлдэгдэл, тооцоотой гарсан байна.	Төсвийг оновчтой удирдаж, авлага өглөгийн тооцоо үүсгэхгүй байх	1	3,229.3								1	3,229.3	
Дүн					6	175,368.9	2	169,216.2			1	2,923.4		3	3,229.3	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	БПК	АХГ-2022/243/НА-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд оруулбал зохих 149 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроон, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	1	-				1	-	1	-			
Дүн					1	-				-	-	-	-	-	-	
Нийт дүн					7	175,368.9	2	169,216.2			2	2,923.4	1	-	3	3,229.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 05 13/АО150058
АХГ- 2020/043/НА-СТА-ТМЗ
Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Барилгын Политехник Коллежийн 2021 санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд оруулбал зохих 149 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроон, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. "хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлөөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчил гаргасан, нягтлан бодогч Н.Нарансүрэнд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Барилгын Политехникийн Коллежийн захирал Г.Нямдулам, нягтлан бодогч Н.Нарансүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ МӨНХБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 05 № 12/А0150053
АХГ-2020/243/НА-СТА-ТЦЗ
Зөрчил арилгах тухай

Утас/факс: 51-264230

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Барилгын Политехник Коллежийн 2021 санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд захиргаа, үйлчилгээний ажилтнуудын илүү цагийг журамд заасан хэмжээнээс өндрөөр тооцоолж, 2,923,362.80 төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгосон.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.3 "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Илүү цагийн нэмэгдэл хөлсийг журамд зааснаас өндрөөр тооцоолж олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын Политехникийн Коллежийн захирал Г.Нямдулам, нягтлан бодогч Н.Нарансүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.СЭРЖМЯДАГ

АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

МӨНХБЯАР

